



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/468

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны С/28 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, Ерөнхий шаардлага MNS5633:2023 стандартын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Дашбаяр (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

Гишүүд:

Ш.Алтантуяа (Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч)

Г.Бямбахишиг (Аймгийн Цагдаагийн газрын Гэр бүл, хүүхдийн ажил хариуцсан мэргэжилтэн)

Г.Цэцэгдарь (Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын хүүхдийн хөгжил оролцоо хариуцсан мэргэжилтэн)

Б.Мандахбаяр (Аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн бүтээгдэхүүн баталгаажуулалтын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: С.Отгонжаргал  
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын гэр бүл, хүүхэд, залууд, жөндөрийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

2. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанар, хүүхдийн хөгжил, хамгаалалд хяналт тавих, үнэлэх зэрэг ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж, дүнг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (Ч.Дашбаяр)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011005